

**БАТЛАВ:**

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГА

----- / А.ЭНХБАТ /

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН :

НОМ-ЭЭЛ ХХК-ИЙН ..... И.БАТТУЯА

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ ГОРХИ-ТЭРЭЛЖ  
БЦГ-Т ХЭРЭГЖИХ БУЙ “ТЭРЭЛЖ ХИЛЛС ЛОДЖ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР...../5209749/

**ХЯНАСАН :**

ГОРХИ ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН  
АЛБАНЫ

АЯЛАЛ      ЖУУЛЧЛАЛ ХАРИУЦСАН      МЭРГЭЖИЛТЭН:

..... / Н.ЭРДЭНЭБИЛЭГ      /

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН: ...../ ШИНЭЦЭЦЭГ /

Боловсруулсан:

НОМ-ЭЭЛ ХХК ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР...../Б.ХИШИГДУЛАМ /

2022 он

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	3
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл .....	3
1.2 Төслийн хүчин чадал.....	4
1.3 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн байдал .....	7
1.4.2 Ус хэрэглээ, шингэн хог хаягдал.....	9
1.5 Ажиллах хүчний тоо, эх үүсвэр.....	9
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	10
2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	13
2.2 Усан орчинд үзүүлэх нөлөөлөл .....	15
2.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл .....	15
2.4 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл .....	16
2.5 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл .....	16
2.6 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл .....	17
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН	
СЭРГИЙЛЭХ, .....	17
БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ .....	17
3.1 Төслийн байршил, төлөвлөлттэй холбоотой сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж .....	17
3.2 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний ...	18
зөвлөмж .....	18
3.2.1 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	18
3.2.3 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах .....	19
3.2.4 Тарималжуулалтын ажлын технологийн зөвлөмж .....	20
3.2.5 Хог хаягдлын менежмент .....	25
3.2.6 Бусад арга хэмжээ.....	27
3.3 Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	27
3.4 Жуулчны баазын зохион байгуулалт, үйл ажиллагаанд анхаарвал зохих санал	26
.....	30
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	33
<i>Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ургамлан нөмрөг хамгаалах/ .....</i>	35
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	35
Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал .....	36
Орчны хяналт, шинжлгээний хөтөлбөр (ОХШХ).....	38

БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь..... **Error! Bookmark not defined.**

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

#### Төслийн нэр

Улаанбаатар хот Налайх дүүргийн нутаг дэвсгэр Горхи-Тэрэлжийн БЦГ-ийн Баргын өвөлжөөнд байрлах “НОМ ЭЭЛ” ХХК-ийн TERELJ HILLS LODGE Жуулчны бааз байгуулах төсөл

#### Төслийн үндэслэл, зорилго

Энэхүү төслийн зорилго нь өмнө үйл ажиллага явуулж байсан 2 га талбайдаа орчин үеийн шийдэл бүхий аялал жуулчлалын стандартаар үйл ажиллагаагаа явуулан гадаадын амрагч хүлээн авч нүүдлийн соёл иргэншлийг сурталчлах, иргэдэд найрсаг үйлчлэх, үйлчилгээний хувьд олон улсын жишиг стандарт эрүүл ахуйн шаардлагад нийцсэн иж бүрэн үйлчилгээг үзүүлэн тухайн орчны газар нутгийг зөв зохистой ашиглан хамгаалж экологийн цэвэр орчныг ханган, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

#### Төсөл хэрэгжүүлэгч

Хувийн хөрөнгө оруулалттай “НОМ ЭЭЛ” ХХК,

Улсын бүртгэлийн дугаар: 9011142131

Регистрийн дугаар: 5209749

Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийг ашиглах зөвшөөрлийн гэрчилгээний дугаар 201478

#### Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Улаанбаатар, Баянгол дүүрэг, 12-р хороо, 6-р бичил хороолол 26-35

Утас: 99054550, 99709478

#### Төслийн байршил


Улаанбаатар хот Налайх дүүргийн нутаг дэвсгэр Горхи-Тэрэлжийн БЦГ-ийн Баргын өвөлжөө

### Хүснэгт. 1 Төсөл хэрэгжих газрын захын цэгүүд

Цэгийн дугаар	Геодезийн солбицол		Талбайн хэмжээ (га)
	X	Y	
1	5304913.743	681777.133	2.0
2	5304926.036	681761.050	
3	5304863.429	681715.687	
4	5304915.040	681647.099	
5	5305089.087	681764.834	
6	5305038.241	681840.917	
7	5304969.040	681793.060	
8	5304959.065	681808.040	

## Таних тэмдэг

Төсөл хэрэгжих талбай



Зураг. 1 Төслийн байршлийн зураг



Зураг. 2 Байршлын Google-ийн зураг

### 1.2 Төслийн хүчин чадал

Тус “TERELJ HILLS LODGE” аялал жуулчлалын бааз нь Горхи-тэрэлжийн БЦГ-т байрлах бөгөөд энэхүү сав газар нь Улаанбаатар хотоос 52 км-т байрлах ба хад асга бүхий уулын тогтоцоороо өвөрмөц байгалийн үзэсгэлэнт газар юм. Уг жуулчны цогцолбор нь нэг ээлжиндээ

60-70 хүн хүлээн авах хүчин чадалтай 21 гэр амралт, орчин үеийн шийдлээр тохижуулсан 6070 хүн хүлээн авах чадалтай зочид буудал, ресторан, бар, халуун хүйтэн устай душ, боловсон бие засах газар бассейн гэх мэт өнөөгийн аялал жуулчлалын баазыг байгальтай хослуулан зохион байгуулсан. Тус төсөлд тусгаснаар 21 гэр буудлаас гадна 3 давхар үйлчилгээний байр баригдах болно.

Уг барилга нь 1 орцтой ба 2 болон 3 давхар тус бүрд 12 буудлын өрөө, ресторан, уулзалтын өрөө байхаар төлөвлөгдсөн. Тус барилга нь тэнхлэгээрээ 40м\*19,5 м хэмжээтэй, 2 давхар тэгш өнцөгт хэлбэртэй, цутгамал бетон шугаман суурь модон каркасан бүтээцтэй, хуйлмал хавтгай дээвэртэй, канад хаус барилга байхаар тусгасан.

1-р давхартаа амралтын өрөө, ресторан, хүлээн авах заал, гал тогооны өрөө


2-р давхартаа амралтын өрөө, ариун цэврийн өрөө, уулзалтын өрөө

Бүх гадна шугам сүлжээний зургийг өгөгдсөн техникийн нөхцлийн шаардлагын дагуу боловсруулж, нарийвчилсан тооцоо, техникийн өгөдөл шийдэл, тайлбарыг хэсэг тус бүрийн зургаас үзнэ.

Байгаль цаг уурын үндсэн өгөгдлүүд нь:

- Газар хөдлөлийн балл 7
- Гадна агаарын тооцоо температур  $-39^{\circ}$
- Цасны ачаалал  $50 \text{ кг/м}^2$
- Галын ангилалын категор В
- Галд тэсвэрлэлийн зэрэг 2-р
- Салхины ачаалал  $-35 \text{ кг/м}^2$






### Буудлын нэгдүгээр давхар



Зураг. 3 1-р давхрын байгуулалт


Хүснэгт. 2 “1-р давхарын байгуулалт”

ТАНИХ ТЭМДЭГ

-  Өрөөний дугаар
-  Цонхны марк
-  Хаалганы марк
-  Огтолын марк, хуудасны дугаар
-  Хэсэглэлийн марк, хуудасны дугаар

Хоёрдугаар давхарт

Өрөөний тодорхойлолт			
Д/д	Өрөөний нэр	Нийт	Талбай М <sup>2</sup>
1	Вестибюль	1ш	87,03
2	Ресторан	1ш	220,76
3	BAR	1ш	9,56
4	Гал тогоо	1ш	68,00
5	Оффисе	1ш	14,75
6	Ариун цэврийн өрөө	5ш	33.7
7	Тамбур	2ш	5.51
8	Агуулах	1ш	22,68
9	Гараж	1ш	185,99
<b>Бүгд</b>			<b>647,98</b>



Хүснэгт. 3 “2-р давхрын байгуулалт”

Өрөөний тодорхойлолт			
д/д	Өрөөний нэр	нийт	Талбай М <sup>2</sup>
1.	Вестибюль	1ш	22,88
2.	Хонгил	2ш	94.12
3.	Амралтын өрөө	7ш	184.79

4.	Ариун цэврийн өрөө	9ш	36.51
5.	Уулзалтын өрөө	1ш	59,49
6.	Интэрнэт/ тоглоом	1ш	65,05
	Бүгд		461,08

### 1.3 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн байдал

**Усан хангамж-** Төсөл хэрэгжүүлэх талбайд шинээр гүний худаг ухах ба түүнийгээ унд ахуйн хэрэгцээндээ ашиглана.

- Цооногийн гүн 115м
- Усны тогтсон түвшин /статик/ 25м
- Цооногийн ашиглалтын усны ундрага 0,8 л/с, - Солбицол :

X	47° 52' 17.82"
Y	107° 25' 47.01"

Газарзүй-Геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лабораторит хийлгэсэн усны химийн шинжилгээний дүгнэлтээр химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Ундны усны чанарын стандарт MNS 900:2005”-н шаардлага хангаж байна.



**Зураг. 4 Төслийн худаг**

**Цахилгаан-** Улаанбаатар хотын Налайх дүүрэг Горхи-Тэрэлжийн БЦГ газарт аялал жуулчлалын зориулалтаар, улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн газар ашиглах 619 тоот гэрчилгээнд үндэслэсэн цахилгаан хангамжийн 10/4.4кВ-ын S-11 160кВт хүчин чадалтай трансформаторын дэд станцтай.



Зураг. 5 Цахилгаан хангамж

**Дулаан хангамж**- цахилгаанаар дулаанаа хангана.

**Харилцаа холбоо**- Улаанбаатар хотын ойролцоо байрлах тул харилцаа холбооны иж бүрэн тоноглолтой.

#### **Төсөл хэрэгжих хугацаа**

Уг төслийг 2015 оноос барилга байгууламж, бусад үйл ажиллагаагаа явуулсан ба төслийн эхний жил буюу 2016 онд 23,7 хувьтай байсан ба 2017 онд 32,5 хувь, 2018 онд 34,2 хувь, 2019 оноос 40,5 хувиас буурахгүй байхаар төлөвлөж байна.

#### **Б.Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал**

Амралтын бааз нь зундаа хоногт нэг ээлжиндээ 15-16, бусад улиралд 5-10 хүн хүлээн авна. Үүний 25%-аар бодоод зундаа өдөрт тогтмол 20 хүн,байнгын ажилчид 10 хүн,бусад улиралд өдөрт тогтмол 10 хүн байнгын ажилтан 10 хүн ажиллана гэж үзвэл:

**Зундаа:** Нийт  $30 \text{ хүн} * 0,3 \text{ кг} = 18,9 \text{ кг}$  30 хоногт буюу сард 567кг, жилд ажиллах хугацаа нь 5 сар буюу 153 хоногоор тооцож үзвэл 1,4тн орчим хатуу хог хаягдал гаргахаар байна.

**Бусад улиралд:** Нийт  $20 \text{ хүн} * 0,3 \text{ кг} = 6,0 \text{ кг}$  30 хоног буюу сард 198кг, Жилд ажиллах хугацаа нь 7 сар буюу 212 хоногоор тооцож үзвэл 1,2тн орчим хатуу хог хаягдал гаргахаар байна. Ингэж үзээд жилдээ нийт 2,6тн орчим хог хаягдал гаргахаар байна.

/Барилгын хог хаягдлыг энд тооцоолон гаргах боломжгүй ба сард 2 удаа тээвэрлэнэ./ Амралтын төв доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гаргахаар байна.Үүнд:

- Хүнсний зүйлийн сав,баглаа,боодол
- Бие засах газрын хаягдал
- Полиэтилен уут,баглаа,боодол
- Хоолны үлдэгдэл
- Бусад

Тус компани нь төслийг хэрэгжүүлэх явцдаа хатуу хог хаягдлыг зайлуулах асуудлыг “Хог хаягдлын тухай” улсын хуульд заасны дагуу холбогдох байгууллагатай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.



Төсөл хэрэгжүүлэгч нь хатуу хог хаягдлын цэгийг зонхилох салхиний доод талд битүү тагтай зориулалтын саванд хадгалах ба байгууламжаас 60м-с багагүй зайтай байрлуулах ёстой.

#### 1.4.2 Ус хэрэглээ, шингэн хог хаягдал

Төсөл хэрэгжих үеийн шингэн хаягдлын эх үүсвэр нь:

- ✦ Хоол бэлтгэлийн явцад гарсан бохир ус
- ✦ Цэвэрлэгээнд хэрэглэсэн бохир ус
- ✦ Ариун цэврийн өрөөнүүдээс гарах бохир ус зэрэг болно.

Төслийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх цэвэр ус, ялгаран гарах шингэн хаягдлын тооцоо Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар болон 14 дүгээр хавсралтан дээр үндэслэн тооцов.

Дунджаар тус амралтын баазын ажиллах хугацаа нь 5 сар буюу 153 хоногт дунджаар 20 амрагч, 10ажилчин , бусад улиралд буюу 212 хоногт дунджаар 10 амрагч, 10 ажилчин гэж тооцвол: (1 амрагч өдөрт 180 л, 1 ажилчин өдөрт 50 л ус ашиглахаар тооцов) **Зундаа:** 153 хоног\* 20 хүн\* 180 л/хоног= 550 м<sup>3</sup> /амрагч/

153 хоног\* 10 хүн\* 50 л/хоног= 76 м<sup>3</sup> /ажилчин/

**Бусад улиралд:** 212 хоног\* 10 хүн\* 180 л/хоног= 381 м<sup>3</sup> /амрагч/

212 хоног\* 10 хүн\* 50 л/хоног= 106 м<sup>3</sup> /ажилчин/

Нийт хэрэглэх усны хэмжээ 1 жилд 1113 м<sup>3</sup> буюу 1 хоногт 3 м<sup>3</sup> цэвэр ус ашиглахаар байна. Уг усны хэрэгцээг өөрийн төслийн талбайд гаргасан худгаас хангана. Үүний 70% буюу 779 тн/жилд шингэн хаягдал гарах тооцоотой байна.

Мөн нийт төсөл хэрэгжих талбай болох 1 га газрын 30% д нь ногоон байгууламж болгохоор төлөвлөхөөр заасны дагуу эхний жилд 700 м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлж мод бут тарина.

Услах хоног	Давтамж	Усны хэрэглээ	Нийт талбай	Нийт усны хэмжээ
153	7 хоногт 1 удаа	1м <sup>2</sup> =4 л	700 м <sup>2</sup>	105,6 м <sup>3</sup>

#### 1.5 Ажиллах хүчний тоо, эх үүсвэр

Уг төсөл хэрэгжихэд нийт 10 хүн ажиллах болно. Төслийн удирдлага зохион байгуулалт дараах бүтэцтэй байх бөгөөд удирдах ажилтнуудыг өндөр зэрэглэлийн зочид буудал амралтын газрын удирдлагаар сургана. Мөн ажилчдын нийгмийн баталгаа, хөгжих орчныг бүрдүүлэхийн тулд байнгын сургалт зохион байгуулна.

#### Хүснэгт. 4 Ажиллах хүчний тоо

№	Эрхэлж буй ажил	Ажилчдын тоо
1	Захирал	1
2	Нярав	1
3	Үйлчилгээний ажилтан	4
4	Тогооч	2
5	Зөөгч	2

Дээрх мэргэжлийн хүмүүс нь доорх үүрэг хариуцлагатайгаар ажил үүргээ гүйцэтгэнэ.

Ерөнхий зүйл:

1. Монгол улсын хөдөлмөрийн хуулийг удиртгал болгон хөдөлмөрийн гэрээ байгуулж ажил үүргийн тодорхойлолтын дагуу ажиллана.
2. Ажлын байрандаа цагийг нарийн баримтлан ажилдаа хоцрохгүй, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрөөх
3. Ажлын байранд архи, тамхи хэрэглэхгүй байх
4. Цаг үргэлж цэвэр цэмцгэр байж, ажлын формыг өмсөх
5. Тодорхой шалтгаанаар ажилдаа ирэх боломжгүй бол удирдлагад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах, өвчилсөн тохиолдолд эмнэлгийн хуудас авчирах
6. Байгууллагын эд хогшил, тоног төхөөрөмжийг ариг гамтай ашиглаж хувьдаа ашиглахгүй байх
7. Хамт олон болон үйлчлүүлэгчидтэйгээ зөв боловсон харьцаж тэдний тавьсан хүсэлтийг хөнгөн шуурхай биелүүлэх
8. Захиргаанд санал хүсэлтээ тавих, асуудал боловсруулан хэлэлцүүлж, ахуй амьдрал, цалин тэтгэмж, тусламжийн талаар санал хүсэлт тавих эрхтэй.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс харахад байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Хүмүүс олноор төвлөрөн бөөгнөрөх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнтэй уялдан хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх
- Төслийн барилга байгууламжыг барьж байгуулах үед 1 га эдэлбэр газар, хөрс эвдрэлд орох, ургамал талхлагдах
- Шингэн хаягдал замбараагүй хаявал гадаргын ус болон хөрс, ургамал бохирдох
- Хийн хаягдал агаар орчинг бохирдуулах
- Технологи үйл явцаа зөв зохион байгуулахгүй бол байгальд нөлөөлөх магадлалтай байна.

Дээр өгүүлснээс дүгнэлт хийхэд байгаль орчинд сөрөг нөлөөлөл бага эрчимтэйгээр нөлөөлөх төслийн ангилалд багтах юм.

Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, ургамал байхаар байна. Иймд төслийн зөвлөмжид дурьдсан болон хууль эрхзүйн баримт бичгийг байнга мөрдөн ажиллах хэрэгтэй.

Энэхүү төсөл нь БЦГ-ын бүсэд байрлах гэж буйн хувьд шинээр барьж байгуулахтай нь уялдуулан төслийн гол сөрөг нөлөөллийг *барилга байгууламжийг барих үеийн ба барьснаас хойшхи ашиглалтын үеийн* гэсэн үндсэн хоёр хэсэгт авч үзэв. Эхнийх нь богино хугацааных боловч нөхөн сэргээх хугацаа шаардах нөлөөллүүд бөгөөд тэдгээрийн эрч хүч, хамрах хүрээ, хугацаа нь барилгыг барих үеийн удирдлага зохион байгуулалтын арга ухаантай багагүй холбоотой байна. Сүүлчийнхийг нь байгууламжийг эзэмшигчдийн өөрсдийн нь үйл ажиллагаатай шууд холбоотой байнгын нөлөөлөл гэж үзэж болно. Голлох нөлөөллийн хамрах хүрээ, эрчмийг нэгтгэж хүснэгт 5 -д харуулав.

**Хүснэгт. 5 Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа**

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	2	3	4	5	6
1	Ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Орчны хөрс, хөрсний ус	0-0.15 га	Боломж бага	Хавар, намар, зуны Улиралд
2	Зам, жим харгуй ихсэх	Хөрс, ургамал	Төслийн автомашины зогсоолоос гадна машин тэрэг байрлуулах	Их	Төслийн туршид
3	Амрагч сувилагчдын бөөгнөрөл ихсэж төслийн хүчин чадлаас хэтэрсэн үйлчилгээ явуулах	Орчны ургамал нөмрөг, хөрс	0-3км <sup>2</sup>	Их	Тогтоох боломжгүй

4	Түймэр	Хүн, мал, эд хогшил, ургамал, ой, хөрс	0-10км <sup>2</sup> түүнээс их	Хүчтэй	Тогтоох боломжгүй
---	--------	--	--------------------------------	--------	-------------------

Эндээс үзэхэд тус төслийн эдэлбэр газар төдийгүй орчны газар нутгийг хамгаалалтад авч, авто хөсгийг зөвхөн тогтоосон замаар явуулж, үйлчлүүлэгчдийн тоог тогтоосон норм хэмжээнээс давуулахгүй байх шаардлагатай. Үл харгалзваас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамлан нөмрөгийг алдагдалд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдож, ургацын хэмжээ буурч, экологийн тэнцвэрт байдал алдагдах нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь амрагч сувилалчдын хөл хөдөлгөөн ихсэх, төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр холжиж олон салаа зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах нь хөрс, усны бохирдол, ургамал нөмрөг алдралд орон хомсдож биомассын хэмжээ багасах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах бүлэгт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

**Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах үеийн гол нөлөөлөл**

- Барилгын материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, барилгыг барих явцад хөрс, ургамал механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах
- Будаг, маажин, цавуу мэтийн химийн бодис асгарснаас хөрс ургамал, хөрсний ус бохирдох, амьд организм хордох
- Нунтаг болон цементийн зуурмаг, шохой асгаж, модны зомгол, золтос, үйрдэс, шилний хагархай зэрэг элдэв төрлийн хог хаягдлаар орчныг бохирдуулах - Төслийн 2 га талбайн хөрс, ургамал бүхэлдээ эвдрэл, элэгдэлд бүрэн орно. **Барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл**
- Объектын орчин тойронд хөрс, ургамлан нөмрөг элэгдэл, эвдрэлд орох
- Зам жим, барилга байгууламжийн орчны хөрс талхлагдах, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх
- Хөрс, ургамал элэгдэл, эвдрэлд орох
- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох зэргээр илэрнэ.

Төслийн байгууламжийг барих эхний үе шатанд объектыг байгуулах, газар шорооны ажил гүйцэтгэхэд тухайн орчны хөрс, ургамал нэн түрүүнд өртөж тэрчлэн явган хүний жим зам тавих, суваг шуудуу татах зэрэгт хотгор гүдгэрийн зарим хэлбэрүүдийн үндсэн төрх хөндөгдөх, шинээр бичил хэлбэр бий болох гэх мэт өөрчлөлтүүд гарч зөвхөн талхлагдах төдийгүй тодорхой хэмжээний газрын хөрсний механик бүтэц, ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Ийм тохиолдолд тухайн объект байгууламж барих хэсгийн өнгөн хөрсийг болгоомжтой авч, овоолго хийж нөхөн сэргээлт болон, цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах нь зүйтэй юм. Ийнхүү

нөхөн сэргээхдээ төсөлд тусгасан зураг төслийн дагуу тухайн орчинд зохицсон ургамал тарих шаардлагатай. Барилга байгууламж барих үеийн нөлөөллийн төрөл нэлээд олон байгаа хэдий ч хамрах хүрээ нь бага, эрчим нь их байна.

Иймд байгууламжийг барьж дууссаны дараа нөхөн сэргээх ажлыг яаралтай хийх шаардлагатай. Ашиглалт жигдэрсний дараа орчинд үзүүлэх нөлөөллүүд нь түүний олон талт үйл ажиллагаатай уялдан хүрээгээ тэлэх магадлалтай байгаа нь ажиглагдана. Ийнхүү тус төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байх сөрөг нөлөөллийг түүний бүхий л хүрээнд авч үзвэл: хөрс дагтарших, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, хөрс хөрсний ус түүгээр дамжин гүний ус бохирдох, биомассын хэмжээ багасах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн, хорхой шавьж хордож устах, мөлхөгч, мэрэгчид, жигүүртэн шувууд дайжих, мод бут өвс ургамал механик гэмтэлд өртөх гэж үзэв.

Энэ бүхэн нь нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан асуудлуудад хайхрамжгүй хандсанаас үүдэлтэй байж болно. Тус төсөлд ажиллагсдын өөриймсөг сэтгэл, санаачилга, нягт нямбай ажиллагаа сайн байх аваас орчноо аливаа бохирдол, эвдрэлээс хамгаалж, хөрс, ургамал нөхөн сэргээгдэх боломжгүйгээр устах аюул, эвдрэлд орох сөрөг нөлөөллөөс сэргийлэх боломжтой.

Эдгээр сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг дараах бүлэгт дэлгэрэнгүй оруулсан бөгөөд тус зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч “Ном Ээл” ХХК нь цаашид мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

### 2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих орчимд агаарын бохирдол харьцангуй бага байна гэж үзэж байна. Энэ нутгийн агаар, ус, хөрс, ургамал байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан бөгөөд ялангуяа уг төсөл хэрэгжих талбай нь хүний суурьшилын бүсээс зайтай, тухайн орчимд агаар орчинд хүчтэй нөлөөлж бохирдуулах эх үүсвэр байхгүй учир тухайн төсөл хэрэгжих талбайн агаар нь харьцангуй цэвэр ба төслийн үйл ажиллагаанаас суурьшлын бүсэд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байна.

Төсөл хэрэгжих орчмын агаарын бохирдлын эх үүсвэр нь барилга байгууламж барих явцад үүсэх тоосжилт, барилгажилтанд ажиллах машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ зэрэг болно.

Мөн агаарын бохирдлын гол үүсвэрийн нэг нь байгалийн хүчин зүйл болох шороон шуурга гэж болно. Чухам ийм үед л тоос, шороо ихээр дэгдэж агаар орчныг бохирдуулна.

Цаашид сувилал ашиглалтанд орж үйлчилгээний явцад амрагч сувилуулагч ирж очих машин механизмуудын түлшний шаталтаас үүсэх хорт хий, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын чанарт хими болон физикийн тодорхой нөлөөллийг бага хэмжээгээр үзүүлэх болно.

Дээрх нөлөөллийн хэлбэрийг доор дурдсан байдлаар ялган төсөөлж болох юм. Үүнд:

- Ургамлын бүрхүүл, бэлчээр тоос шороонд дарагдах
- Агаар дахь тоосны агууламж ихсэн хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлөх

Иймд төсөл хэрэгжих орчин нь БЦГазар гэдгийг харгалзан үзэж хүний үйл ажилагаанаас үүдэлтэй тоосны сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам, хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох нь нэн чухал юм.

Тээвэрлэлтийн /Барилгажилтын/ үед эвдэрсэн газрыг тухай бүр нөхөн сэргээх, аль болохоор олон салаа зам гаргахгүй байх, амрагчид ирж очих гол замыг цаашдаа хатуу хучилттай болгох зэрэг бололцоотой бүхий л арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

#### Хийн хаягдлын үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Автомашин утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310 г, дизель хөдөлгүүр 80-100 г хорт бодис ялгаруулдаг ажээ. 1 кг шатахууныг литрт шилжүүлэн (бензин  $q=0.725$ , дизель  $q=0.825$ ) бодож, түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашин утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлохдоо, бензиний хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба азотын ислийн агуулалтыг, дизель хөдөлгүүрт бол хөө тортогийн агуулалтыг үндсэн үзүүлэлт болгодог.

#### Хүснэгт. 6 Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ

Бохирдол	Автомашин асаалттай, сул зогсолттой байх үед	Машин хурдтай явж байх үед (60 км/цагаас дээш)	Машин тойргоор эргэх үед	Машины хурд саарч байх үед (60 км/цагаас доош )
СО (%)	4 – 9	< 1 – 8	1 – 7	2 – 9
НС, С <sub>6</sub> Н <sub>14</sub> (ppm)	500 – 1000	50 – 80	200 – 800	3000 – 12 000
NO <sub>x</sub> (ppm)	10 – 50	1000 - 4000	1000- 3000	5 – 50

Дээрх хоёр төрлийн хөдөлгүүрийн утааны дундаж найрлагыг дараах хүснэгтэд харуулсан ба энэ нь үндсэндээ байгаль орчинд цацагдаж байгаа утааны техникийн болон мониторингын хяналтын үзүүлэлт болон ашиглагдах ач холбогдол бүхий билээ. **Хүснэгт. 7 1 Автомашин утааны бүрдэл найрлага**

№	Бүрдэл	Хөдөлгүүрийн төрөл		Тайлбар
		Бензин	Дизель	
1	Азот (%)	74-77	76-78	Хоргүй
2	Хүчилтөрөгч (%)	0.3-8	2-18	Хоргүй
3	Усны уур (%)	3-5.5	0.5-4	Хоргүй
4	Нүүрсхүчлийн хий (%)	5-12	1-10	Хоргүй
5	Нүүрстөрөгчийн исэл (%)	1-10	0.01-0.5	Хортой
6	Азотын исэл (%)	0.1-0.5	0.001-0.4	Хортой
7	Альдегид (%)	0.0-0.2	0-0.009	Хортой
8	Нүүрс-устөрөгчид (%)	0.01-0.02	0.01-0.5	Хортой
9	Хүхэрлэг хий (%)	0-0.002	0-0.03	Хортой
10	Хөө тортог (г/м <sup>3</sup> )	0-0.44	0.01-1.1	Хортой

11	Бенз (а) пирен (г/м <sup>3</sup> )	<0.00002	<0.00001	Хортой
----	------------------------------------	----------	----------	--------

Хүснэгт 13-оос харахад, 1л бензин шатаахад ялгарах хорт бодисын хэмжээ нь дизель түлшнийхээс дунджаар 3.1 дахин их байгаа бөгөөд зөрүүгийн энэ хэмжээ ерөнхийдөө 3-4 хооронд хэлбэлзэж байдгийг судалгаагаар тогтоосон байна.

## 2.2 Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбай нь Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын Өвөр Горхийн гол руу баруун талаас нь орж ирдэг. Гадаргын ус нь Өвөр Горхийн хөндийд байгаа намаг сайр дагаж тогтсон түр урсгалтай горхи, Бургастайн амны хөндийд байгаа мөн намаг, сайр дагаж тогтсон түр урсгалтай горхи, Хадат амны нарийн жалга дагаж хур борооны үед богино хугацаанд үүсдэг түр ширүүн урсгалтай хурын үер зэргээс тогтож байна. Мэлхий хадны ар талаар зүүн хойноосоо урагш чиглэсэн 500м хүртэл өргөн намгархаг хөндийтэй 1 м хүртэл өргөн сайр дагасан урсгалтай горхи байгаа нь ажиглагдав. Уг горхи нь хээрийн судалгаа хийх үед цас, мөсөнд хучигдсан байв. Мөсний зузаан хуурай сайр дагуу 0.0-20 см, булагласан хэсэгхэн газарт 0.6 м хүртэл байв.

Хүний анхаарал болгоомжгүй үйл ажиллагаа, зүй зохисгүй ашиглалт, хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяж асгах, тээврийн хэрэгслийн шатах тослох материалын асгаралт зэргээс гадаргын усан орчинд сөрөг нөлөөлөл учирч болзошгүй. Мөн төслийг хэрэгжүүлэхэд гүний усыг ашиглах нь гүний усны нөөцөд тодорхой хэмжээгээр нөлөөлөх болно.

## 2.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Өвөр Горхийн Бургастайн ам гэдэг газар нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс-био уур амьсгалын Хангайн мужийн өндрийн бүсшил бүхий ХангайХэнтийн өмнөдийн хэв шинж бүхий 52 дугаар тойрогт хамрагдана. Энд уулын бэлээр нугын, уулын хойд хажуугаар уулын ширэгт-тайгын, уулын хар шороон, уулын ойн бараан, уулын хар шороон, уулын хар хүрэн хөрснүүд тус тус тархана [Үндэсний атлас, 1990].

Төслийн барилга байгууламж баригдахтай зэрэгцэн дараах үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлөл үүснэ.

- Байгууламжийн материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, төсөл хэрэгжих явцад хөрс, ургамал, мод бут механик гэмтэлд өртөх
- Барилгын суурь ухах, цутгах зэрэг үйл ажиллагаанд газрын хөрс бохирдох
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах
- Амрагч сувилагчдын тоо олширч түүнийгээ даган тээврийн хэрэгсэл ихэссэнээр зам жим олширч элэгдэл ихсэх, эрэг мөргөцөг нурах, эвдрэх гэх мэт болно.

## 2.3 Ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Горхи-Тэрэлжийн раойны Баргын өвөлжөө гэдэг газар нь Евро-Азийн шилмүүст ойн мужийн Өвөр байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрогт багтдаг. Энд Шинэс-хус бүхий холимог ойтой. Ургамлын бүлгэмдлийн хувьд алаг өвс- улалж-үетэнт, алаг өвс -үетэнт бүлгэмдэл зонхилж байна. Тэнд нийт 20 овогт хамаарах 38 төрлийн 42 зүйл ургамал бүртгэгдэв. Зонхилох овгууд нь үетэн, нийлмэл цэцэгтэн, тэргүүлэгч цэцэгтний овгийн ургамлууд орж байна. Энд энгийн, бэлчээрийн ач холбогдол бүхий зүйл ургамлууд нилээд байна. Харин нэн ховор, ховор ургамал байсангүй.

Ургамлын амьдралын гол нөхцөл болсон гэрэл, дулаан, усан хангамж, хөрсний бүтэц, эрдэс тэжээл, агаарын хүчилтөрөгч хангамжаас шалтгаалан ургамлын бүтэц-экологийн өвөрмөц бүлгүүд бий болсон байдаг.

Барилга байгууламж барих болон төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр амрагчдын хөл хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг/ зүйлийн бүрдлийн хэвийн байдалд өөрчлөлт гарч, орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдаж, тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно.

#### **2.4 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл**

Төслийн талбай орчмын нутаг нь монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар (Банников, 1954) Хэнтийн тойрогт багтана. Хэнтийн тайгын голлох элемент болох олон зүйлийн хөхтөн амьтдын тархалттай. Хан Хэнтийн дархлагдсан нутгийн хүрээнд 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй хөхтөн, суурин болон нүүдлийн 250 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 3 зүйл могой, 1 зүйл бах, 1 зүйл гүрвэл болон 9 зүйл загас тэмдэглэгдсэн байдаг.

Төслийг бариж байгуулах болон хэрэгжүүлэх хугацаанд амрагчид, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлэх талтай.

#### **2.5 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл**

Горхи-Тэрэлжийн БЦГ –ийн Баргын өвөлжөөнд байрлана. Уг төсөл хэрэгжих талбай нь газрын гадарга болон хэвлийн бага зэрэг эвдрэлтэй, ихэнх хэсэг харьцангуй унаган төрхөө хадгалсан, байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөөгөөр бага зэрэг эвдэрсэн, одоогийн байдлаар хог хаягдалгүй байна.

Хэдийгээр аялал жуулчлалын төв барьж байгуулах талбай эвдрэлд ороогүй ч гэсэн барилга байгууламж барих явцад энэ орчны гадаргад ямар нэг хэмжээгээр өөрчлөлт орох болно. Тухайлбал, төслийн барилга байгууламж барих явцад газрын гадаргыг суурь тавих зорилгоор ухах, хүнд тоног төхөөрөмжүүд байршуулах, ойр орчимд нь шинээр автомашины олон зам гаргах зэргээр сэвсгэр хурдаст гадаргад том, жижиг янз бүрийн хэмжээтэй нүх, хонхор, ховил зэрэг хотгор гүдгэрийн сөрөг хэлбэрүүд багагүй үүснэ. Энэ нь нэг талаас байгалийн уугуул төрхийг өөрчлөхөөс гадна цаашид БЦГ-ын гадаргыг эвдрэлд өртөх нөхцлийг бүрдүүлнэ. Иймд төсөл хэрэгжүүлэгч энэ орчны гадаргад бага ч гэсэн гарсан өөрчлөлт бүрийг амралтын газар барьж дууссаны дараа буцаан хуучин хэвэнд нь оруулах нь зүйтэй.

Жуулчны баазыг барьж байгуулах явцад гарч болох сөрөг нөлөөллийг товч дурьдвал:

- Барилга барих явцад барилгын суурь ухах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс үүдэн хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, үүний улмаас элсэнцэр хөрс салхинд хийсэх, элсжилт үүсэх
- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр хөрс, хөрсний ус бохирдох, бичил биетэн устах, хордох
- Болзошгүй тохиолдлоор гал алдах, түймэр гарах

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх шаардлагатай.



## 2.6 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Горхи-Тэрэлж БЦГ нь аялал жуулчлал хөгжсөн, цаашид ч ихээхэн хөгжих ирээдүйтэй нутаг юм. Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь улс орон нутгийн төсөвт багагүй орлого оруулах, зуны улиралд ажлын цөөнгүй байр гардаг нь ажилгүйдлийг багасгах, хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх чухал хүчин зүйл болж байна. Ийнхүү байгалийн үзэсгэлэнт нөхцөл бүрдсэн энэ нутагт амралт сувилалын газар ихээхэн хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлж буй боловч тухайн орон нутгийн экологийн чадавхаас хэтэрсэн ажил үйлчилгээ эрхлэх хэт олон том жижиг бааз байгуулж хүн амын төвлөрөл бий болгох хөл хөдөлгөөн ихэсгэхээс аль болохоор зайлсхийх, тусгай хамгаалалтын бүс нутгийн дүрэм журмын дагуу зохих хязгаарлалт хийх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд нэгэнт байгуулагдсан болон байгуулах гэж буй амралтын газрууд нь байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамгийн бага хэмжээнд хүртэл нь бууруулах талаар туйлын хариуцлагатай хандаж идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь чухал юм.

Төслийн барилгын ажлын тоос болон дуу чимээний нөлөө нь ойролцоо нутаглах иргэдэд үзүүлэх болно. Нутгийн иргэдийн ашигладаг худгийн ойролцоо гүний усыг ашигласнаар бага гүний усны түвшин буурч энэ нь ойролцоох өрхүүдэд шууд нөлөөлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

Улаанбаатар хотын Налайх дүүргийн Горхи-Тэрэлжийн БЦГ-ийн Баргын өвөлжөөнд байрлах TERELJ HILLS LODGE жуулчны бааз байгуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын явцад хийсэн судалгаа, шинжилгээний ажил, холбогдох мэргэжлийн экспертүүдийн гаргасан үнэлгээ, дүгнэлтүүдийг үндэслэн төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчиндоо үзүүлэх болзошгүй болон гол сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах болон арилгахад дараах зөвлөмж, арга хэмжээ, стандартын шаардлагыг мөрдлөг болгон ажиллах, цаг тухайд нь авч хэрэгжүүлэхийг төсөл хэрэгжүүлэгч “Ном Ээл” ХХК-ийн удирдлагад зөвлөж байна.

#### **3.1 Төслийн байршил, төлөвлөлттэй холбоотой сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж**

- ТХГН-ын даацаас хэтрүүлэхгүйн тулд өөрийн хүчин чадлын хэмжээнээс давсан үйлчилгээ үзүүлэхгүй байх.
- Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээнд заасан нөхцөл, эрх үүргийн дагуу үйл ажиллагаа явуулж, зориулалтын дагуу ашиглах, зөвшөөрөл бүхий газрын хил, зааг дотор байх
- Тухайн төслийн барилга байгууламж, үйл ажиллагаа нь орчны суурьшил, нягтрал, хүрээлэн буй орчны даац хэвийн байх нөхцөлийг алдагдуулахгүй байхаар төлөвлөгдсөн байх
- Эдэлбэр газрын нийт талбайн 30-с багагүй хувьд ногоон байгууламжтай, хөл газрын ургамалгүй байлгах ёстой.
- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээнд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээг дараах хүснэгтэд заасан хэмжээнээс багагүй байвал зохино.

### **3.2 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж**

#### **3.2.1 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

- Төслийн үйлчилгээнд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал утааны шүүлтүүр ашиглах,
- Төсөл хэрэгжих орчмын агаарт жилд 1 удаа буюу орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах
- Ахуйн хог хаягдлыг ариун цэврийн бүсийн гадна, түүнээс 60м-ээс багагүй зайд, салхины зонхилох чиглэлийн дагуу, төслийн барилга байгууламжийн доод талд ус үл нэвтрэх дотортой, зориулалтын саванд цуглуулна.
- Төслийн барилга байгууламжийн зураг төсөлд тусгагдсан явган зам, тоглоомын талбай, тээврийн хэрэгслийн зогсоол зэрэг газруудыг технологийн дагуу хучилт хийж байгуулна.
- Халаах, хөргөх хэрэгслүүдэд ашиглах пропан, ферон зэрэг хийг бөөнөөр нь авч технологийн бус нөхцөлд хадгалах, хөргөх төхөөрөмжийг мэргэжлийн бус хүнээр цэнэглүүлэхийг хориглоно.
- Төсөлд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох

#### **3.2.2 Унд-ахуйн усны чанартай холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:**

- Унд ахуйн зориулалттай ус нь халдварт болон нутагшмал өвчин тархах аюулгүй, физик үзүүлэлт, химийн найрлагаараа хор нөлөөгүй, мэдрэгдэх чанараараа харшлахгүй байх нөхцлийг хангасан байх ёстой. Усны чанарын найрлага нь “MNS 900-2005. стандартын шаардлагыг хангасан байх
- Усны тоолууртай болох
- Ус ашиглалтын гэрээг дүүргийн ЗДТГ болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах
- Ундны ус хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах зорилгоор цэвэр ус нөөцлүүрийн сав ашиглах.

#### **Гүний худаг гаргах, ашиглагтай холбоотой арга хэмжээнүүд:**

- Гүний худгийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж, тохижилтыг хийж, паспортжуулж, тоолуур суурилуулах;
- Унд-ахуйн усны хэрэгцээг хангах гүний худаг барьж, түүнийг ашиглаж эхлэхийн өмнө усны дээжийн шинжилгээг орон нутгийн холбогдох лабораториор хийлгэх ба тухайн шинжилгээний дүнг харгалзан ЭАХСХ /эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын/-н байгууллагаар дүгнэлт гаргуулсны үндсэн дээр ашиглах;
- Жилд нэг удаа усны ерөнхий шинжилгээ хийлгэх, худгийн байдал, тоног төхөөрөмж, бүх шугам хоолойнуудад ерөнхий үзлэг хийнэ. Үзлэгийн үр дүнг үндэслэн засварыг гүйцэтгэж ашиглалтын найдвартай ажиллагааг хангах;
- Гүний худгийн ажиллагааны горим алдагдах үндсэн шалтгаан нь шүүлтүүр чулуулгаар дүүргэгдэх, ус хүлээж авах тор бохирдох, худгийн бэхэлгээг горимын дагуу хийгээгүйгээс, сальник муу болон байхгүй үед, насосыг байн байн ажиллуулах, авах усны хэмжээг өөрчлөх болдгийг анхаарах;

#### **Усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс ба түүний дэглэм:**

- Унд-ахуйн гүний худгийн эргэн тойронд эрүүл ахуйн бүс тогтооно. Усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс нь эрүүл ахуйн хориглолтын ба эрүүл ахуйн хязгаарлалтын бүсээс тогтоно.
- Ус хангамжийн эрүүл ахуйн хориглолыг бүсийн эргэн тойрныг хашиж хамгаалан байнгын харуул хамгаалалттай байлгах бөгөөд худгийн таг, салхивчийг битүүмжлэн хялбар нээх, эвдэх боломжгүй болгоно.
- Эрүүл ахуйн бүсийн талбайг тогтмол цэвэрлэж, хог хаягдлыг зайлуулж, хөнөөлт шавьж мэрэгчийн устгалыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай. Эрүүл ахуйн хориглосон бүсэд гадны хүн орох, авто тээврийн ба зөөврийн хэрэгслэл байрлуулахыг хориглох;
- Бохир усны цооног, бие засах газрыг эрүүл ахуйн бүсийн гадна байрлуулна;
- Эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, тогтоох нөхцөл боломж хангагдаагүй болон бүсийн дэглэм зөрчигдөж байгаа усны эх үүсвэрийг хүн амын ус хангамжийн зориулалтаар ашиглахыг хориглоно.

### 3.2.3 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Тухайн төслийн барилга байгууламж, үйл ажиллагаа нь орчны суурьшил, нягтрал, хүрээлэн буй орчны даац хэвийн байх нөхцөлийг алдагдуулахгүй байхаар төлөвлөгдсөн байх
- Төслийг хэрэгжүүлэх явцад төслийн талбай болон түүний ойр орчимд олон салаа зам гаргахаас зайлсхийх
- Хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах, бохирдуулахаас урьдчилан сэргийлж, зам талбайн тэмдэгжүүлэлтийг хийх
- Хашаа, хязгаараас гадна элдэв, хог хаягдал хаяхгүй, газрын төрх, төслийн талбайн хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх
- Төслийн талбай орчмын хөрш зэргэлдээ нутгийг хариуцан хамгаалах
- Төсөл хэрэгжих талбайн тарималжуулалтын болон цэцэрлэгжүүлэлтийн талбайн ургамлан бүрхэвчийн нягтралыг даруй нэмэгдүүлэх, тус үнэлгээний тайлангийн ногоон байгууламж байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэх
- Барилга байгууламж барихдаа ТХГН-ын тухай хууль болон БЦГ-ын хязгаарлалтын бүсийн дэглэмийг чанд мөрдөн ажиллах
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, ашиглах газрын хэмжээг зөрчих, өөр зориулалтаар үйл ажиллагаа явуулах, барилга барихыг хориглоно.
- Төслийн талбай ойр орчмын уул хад, энгэр бэлийн байгалийн тогтоцыг эвдэх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, нэн ховор ургамлыг түүх, дээж коллекц хийхгүй байх
- Аялал жуулчлалын цогцолбор байгуулах ажлын хүрээнд хийгдэх, их бага гэлтгүй нүх цооног, суваг шуудуу, барилгын суурь, талбайн хөрс цэвэрлэгээ, тэгшлэлт зэрэг газар шорооны бүх ажлын үед хөрсний үржил шимт давхаргыг хуулж тусад нь овоолж хадгалах, буцаан нөхөн сэргээлтэд ашиглах;
- Ургамлын нөхөн сэргээлтийн ажлыг MNS 4918:2000, MNS 4919:2000 стандартын дагуу хийж гүйцэтгэх.
- Аялал жуулчлалын баазын хил зааг дотор явган зам, талбай, автомашины зогсоолын талбай зэргийг байгалийн чулуун, хайрган болон бусад байдлаар хучилт хийх;

- Аялал жуулчлалын цогцолборын хил заагийг хязгаарласан өнгө үзэмж төгс, хаяг бүхий хайлс хашлага хийж, орж гарах нэг хаалга, авто замтай байх;
- Хөрсний хими, физик шинж чанар, хүнд металын шинжилгээг жилд нэг удаа хийлгэх.

### 3.2.4 Тарималжуулалтын ажлын технологийн зөвлөмж

Төслийн талбайн хөрс ургамлыг элэгдэл эвдрэлээс хамгаалах, ногоон байгууламж байгуулах талаар дор дурдсан зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна. Үүнд:

- Эдэлбэр газрын нийт талбайн 30-с багагүй хувьд ногоон байгууламжтай, хөл газрын ургамалгүй байлгах ёстой.
- Төслийн талбайд ургасан болон хариуцан хамгаалах талбайн захаар байх ойн санг хамгаалж, арчилж тордох, барилгын ажлын үед болон зураг төслийн төлөвлөлтийн үед орчны мод, бут сөөг, бусад ургамлыг гэмтээхгүй байх - Хөндөхгүй байхаар төлөвлөж ажиллах шаардлагатай.
- Барилга объектын талбайгаас бусад сул газрыг бүрэн хэмжээнд зүлэг ургах нөхцөлөөр бүрэн хангах, ургамалжуулах, тариалсан ургамлыг тухай бүр нь арчилж тордох арга хэмжээ авч хэрэгжүүлж байх

Тарималжуулалтыг тайлангийн зөвлөмжид заасан технологийн горимын дагуу явуулах шаардлагатай ба мэргэжлийн байгууллагаас технологийн нэмэлт заавар, зөвлөгөө авч хэрэгжүүлэх

#### **Зүлэг тарих товч заавар:**

Тарих талбайн хөрсийг 20 см гүн байхаар тооцож бэлдэх / Чулуу, хог хаягдалгүй байх чулуурхаг хатуу хэсгийг ухаж авч хаян оронд нь органик бордоогоор бордсон хөрс хийх /Талбайг тэгшилж үрийг тарихаас өмнөх 10 см гүнд нэвтэрхээр услах. Үрийг гараар жигд цацаж тараах /1 м.кв-д 40 гр нормтой /0,5 -1 см зузаантай элсээр жигд хучих. Үрийг тарьсны дараагаар 5 см гүнд нэвтэрхээр услах. Цаашид өглөө оройд байнга услах 6, 7 саруудад зориулалтын машинаар тайралт хийх /өтгөн ургуулах зорилготой/ Өвөл буюу тарьснаас хойш бүхий л хугацаанд гишгэж талхлахгүй байх. Сонгосон талбайгаас хамаарч төсвийг байгууллага болгон жичдээ гаргаж өөрийн нөхцөл бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэх ба хугацааг өөр өөрийн боломжоор тогтох

#### **Тарималжуулалтад зориулж мод сөөгийг сонгон авах, сүүлгахад бэлтгэх**

Ногоон байгууламж байгуулах нь зарим төрлийн хорт хийн хэмжээг эрс багасгах бололцоо бий. Судалгаанаас үзэхэд шилмүүст мод хүхэрлэг хийг илүү шингээх чадвартай ба түүний агаар дахь агууламжийг 2 дахин багасгадаг байна. Цэцэрлэгжүүлэлтэд зориулж мод, сөөг, ургамлыг ойгоос болон мод үржүүлгийн газраас шилжүүлэн суулгахдаа юуны өмнө авах модоо сайн шинжиж судлах шаардлагатай (Геоэкологийн хүрээлэн, Мод тарих, ногоон байгууламж байгуулах нь, УБ 2005).

#### **Мод тарих хялбаршуулсан арга**

1. Модыг хавар дөрөвдүгээр сарын 25-наас, тавдугаар сарын 25 хүртэлх хугацаанд тарих нь хамгийн үр дүнтэй байдаг ажээ.
2. Өөрийн сонгож авсан газраа 50-60 сантиметрийн гүн, 70-80 сантиметрийн өргөнтэй ухаж бэлтгэнэ.

3. Ухаж бэлтгэсэн нүхэндээ 50 хувь хар шороо, 30 хувь элс, 20 хувь хөх бууц болон бусад бордоог хийнэ.
4. Суулгацыг тарихдаа бэлтгэсэн нүхнийхээ голд үндсийг нь нугалалгүйгээр жигд тарааж, суулгаж өгнө.
5. Суулгасныхаа дараа хөрсийг сайтар нягтаршуулж, гишгэж өгөөд нэг модыг 40-60 литр усаар усална.
6. Өглөө оройн цагт 30-40 литр усаар нэг модыг нэгээс хоёр удаа услах бөгөөд, услах хоног нь долоогоос арав хоног. Суулгаснаас хойш арван сард нэг удаа цэнэг усалгааг хийх бөгөөд усалгаа хийх явцдаа хөрсний сийрүүлэлтийг хийж өгдөг байна.
7. Модоо тарьсан цагаас хойш гурван жилийн дараагаас арчилгаа усалгааг хийх шаардлагагүй болдог ажээ.
8. Мод сөөг тарьсны дараа талбайгаа зүлэгжүүлэхийн өмнө мод сөөгний нүхнээс гарсан хайрга, чулууг зөөж цэвэрлээд, шим тэжээл муутай газрын хөрсийг 20-30 сантиметр гүн хагалж хайрга чулууг цэвэрлэж аваад үлдсэн шороог зөөсний дараа хүрэн хөрсийг 2.5х2.5 сантиметрийн гишгүүрээр гишгиж, ургамлын үндэс болон бусад хогноос цэвэрлэж, гишгэсэн хар хүрэн хөрсийг 20 сантиметрээс доошгүй зузаан дэвсэж гадаргууд жигд тарааж тэгшилснээр зүлэг тарих талбай бэлэн болно. Үрийг нэг метр квадрат талбайд 50-80 грамм орохоор тооцоолж салхи багатай тогтуун өдөр талбайд жигд цацаад тармуураар самнасны дараа элсээр нэгээс хоёр сантиметр зузаан хучина.
9. Үүний дараа 50-100 килограмм жинтэй булаар булдаж зөөлөн шүршиж услана. Зүлэгжүүлэх ажлыг мод сөөг тарьсны дараа тавдугаар сарын хоёрдугаар хагасаас долдугаар сарын 10-нд багтааж тарьдаг байна. Тарьсан үрээ соёолтол хөрсийг нь чийгтэй байлгахын тулд өдөр бүр өглөө оройн сэрүүнд нэг метр квадрат талбайд 30-40 литр ус, үр соёолсноос хойш нэг метр квадрат талбайд 20-30 литр ус орохоор бодож долоо хоногт гурваас дөрвөн удаа услах бөгөөд гандуу үед өдөр бүр услах хэрэгтэй байдаг ажээ.

### **Модны нүх ухаж бэлтгэх**

1. Цэцэрлэгжилт хийх талбайд шилмүүст /гацуур.нарс, шинэс/ модны нүхийг ухаж бэлтгэхдээ уулнаас ул хөрстэй байдгийг харгалзан нүхний хэмжээг 0.8-1.0 метрийн голчтой, 0.7-0.8 метрийн гүнтэй нүхийг ухаж бэлтгэнэ. Ухсан нүхнээс гарсан хөрс, шорооны байдлыг харгалзан нүхний 75 хувьд нь үржил шимт хар шороон хөрс, хөх бууц 10 орчим кг-ыг нэмж хийн сайтар хутгаж тэгшилж орхино.
2. Ухсан нүхнээс гарсан үржил шимгүй буюу хайргыг зөөж зайлуулан оронд нь хар шороон хөрснөөс бэлтгэн тавина. Энэ нь мод суулгах үед нэмэлт болон чигжихэд хэрэглэгдэнэ. Хуучин шороог болж өгвөл хэрэглэхгүй байх нь чухал. Учир нь хуучин бохир, үржил шимгүй, бүтцээ алдсан шороо, хөрсний үүрэг гүйцэтгэж шинэ суулгацны их, бага ямар нэг хэмжээгээр таслагдсан үндсийг цааш ургаж төлжихөд хангалттай шим тэжээл өгч чаддаггүй. Харин нарсны суулгац суулгах нүхэнд хар шороо 40 хувь, элс 60 хувь байхаар бодож сайтар хутган хольж бэлтгэнэ. Нарс ихэвчлэн элсэн болон хөнгөн хөрсөнд ургадаг онцлогтой. Модны нүх ухсан газар нь хөрсний сүврэлт ихтэй /ус барих чадваргүй


бүтэцтэй/ бол нүхний ёроолыг шар шавраар өнгөцхөн шавардаж өгч болох ба үндсэн хөрсийг бүрэн солих шаардлагатай.

### Навчит модны нүх ухаж бэлтгэх

Цэцэрлэгжилтэнд таригдах навчит модны нүхийг ухаж бэлтгэхдээ шилмүүст модны нүхнээс арай бага хэмжээтэй байна. Улиасуулгах нүхийг 0.5-0.6м гүн, 0.5-0.8 м голчтой ухажбэлтгэнэ. Ухсан нүхэнд хар шороон хөрс бордооны холимгыг нүхний 75 хувьд нь болохуйц хэмжээгээр голд нь шовгор байдлаар хийж бэлтгэнэ. Улиангар, хус нь уулнаас ул хөрстэй ирэх боловч дээрх хэмжээнд /нүхэнд/ төдийлөн харшлахгүй юм.


### Бут сөөгний нүх ухаж бэлтгэх

1. Цэцэрлэгжилтэнд таригдах төрөл бүрийн бут сөөгний нүх 50-60 см гүн, 40-50 см голчтой байна. Нүхэнд хийх шороо шим тэжээл сайтай хар шороон хөрс байх ба ухсан нүхнээс гарсан шороог ашиглаж болохоор бол /чулуу хайргагүй эсвэл хэт их шаварлаг юмуу дангаараа элс биш/ түүн дээр 2-4 кг хөх бууц, 75-100 гр фосфорын бордоо нэмж сайтар хольж хийнэ.
2. Ургамлан хашлага тарих шуудуу нь 50 см өргөн, 50 см гүнтэй байна. Шуудуунд хийх шорооны хэмжээ шуудууны 75 хувьтай тэнцэх хэмжээнд байна. Ухсан шуудуунаас гарсан шороог ашиглах боломжтой бол хар шороо, бууц, эрдэс бордоог дээрх хэмжээгээр хольж сайжруулсан хэлбэрээр ашиглаж болохоос гадна дан хар шороог ашиглаж болно.
3. Ер нь олон жил талхлагдаж хөрсний үржил шим бүхий давхарга байхгүй болсон, хог болон бусад зүйлээр их бага ямар нэг хэмжээгээр бохирлогдсон байдаг учир шинээр хийх тохижилт, цэцэрлэгжилтэнд хуучин хөрсийг ашиглахгүй байх нь зүйтэй юм.
4. Мод бут сөөгний нүх ухаж бэлтгэх явцад хөрсний бүрэн шинжилгээ хийлгэчихвэл цаашид ногоон байгууламжаа өргөтгөх, услах, бордох, ямар ургамал таривал зохих талаар өргөн мэдлэгтэй болно.
5. Харин бөөрөлзгөнө тарихаар сонгосон талбайн хөрсний гүний ус 1.5 метрийн гүнд тархсан, хучиж өвөлжүүлэхэд тохиромжтой хөнгөн бүтэцтэй байх нь чухал юм.
6. Бөөрөлзгөнө үндсээрээ мөлхөж ургадаг тул хоёр бутны хоорондох зайг 3 метрээс багагүй байхаар бодож талбайг бэлтгэх хэрэгтэй. Бөөрөлзгөнийг шуудуунд тарих нь илүү тохиромжтой бөгөөд 35-40 см гүн, 50-70 см өргөнтэй шуудуу ухаж бэлтгэнэ.
7. Нэгэнт бэлтгэж бэлэн болгосон нүх, шуудуугаа тарилт хийхийн урд өдөр 1-2 удаагийн давтамжаар хантал нь усалж өгнө.Энэ нь хөрсний чийг багтаамшилтанд их тустай.




## Зураг. 6 Суулгац тарих бүдүүвч

Зураг. 8 Нэг настай суулгац тарих бүдүүвч



Зураг. 7 2-3 настай суулгац тарих бүдүүвч

Навчит модны суулгац

Навчит модны суулгацыг хэмжээ ба чанараар нь 1, 2, 3-р зэрэг гэж ангилдаг. Навчит модны суулгацын гадаад байдал нь хэвийн, холтос нь шалбарч гэмтээгүй, өвчинд нэрвэгдээгүй, нахиа нь хугацаанаасаа урьтаж дэлгэрээгүй, уян зөөлөн найлзуур мөчир ихтэй, гувар нь бүдүүвтэр, бат бэх, үндэс ихтэй, өсөлт сайтай байх ёстой. Өөрөөр хэлбэл гадаад төрх байдлаараа мод хэлбэрийг олсон, салаа оройгүй, гаж хэлбэргүй хэвийн ургалт өсөлттэй мод байна. Модны титэм зөв хэлбэртэй, гол ишний үзүүрээсээ гуравны хоёр нь салаалсан мөчиртэй байна.

Үндэсний хувьд өсөлт хөгжилт сайтай гурваас доошгүй гол үндэстэй, гол үндэснээс салаалсан сахлаг үндэс ихтэй байх бөгөөд үржил шимт шороотой нь хамт тээвэрлэнэ. Мод үржүүлгийн газраас техник хэрэгслээр ухаж авсан Улиас, Хайлаас зэрэг мод хөнгөн, элсэрхэг, сул хөрстэй газар байсан бол тэр нь асгарч үндэс нь ил гарах явдал бий. Ийм үед ухаж авсан модоо усан зуурмагт яаралтай хийх, нойтон элс юм уу шороогоор хучих, шан татаж үндсийг нь далд ортол сул шороогоор булж услах зэргээр үндсийг нь нарны халаалтаас хамгаалах хэрэгтэй. Тарих модны хэмжээний хувьд 3 - 6 м хүртэл өндөр байж болох бөгөөд төрөл, чанарын зэрэглэлээс хамаарч янз бүр байх боловч навчит модыг мод үржүүлэг, ойгоос авах стандарт УСТ1135-74-ийг баримтлан ажиллах шаардлагатай.

Ойгоос буюу мод үржүүлэх талбайгаас суулгацыг авахдаа урд зүг буюу нар харсан талд нь даавуу уяж тэмдэг тавина. Энэ нь модны нар луу харсан талыг солихгүй байх зорилготой бөгөөд модны байгальд ямар зүг рүү харж, ямар байрлалтай байсан нь тухайн мод орчин нөхцөлдөө зохицон ургахад чухал нөлөөтэй.

Шилмүүст модны суулгац

Хэмжээ, чанараар нь 3 зэрэгт хуваах бөгөөд гадаад байдал, хэлбэрт тавигдах шаардлага навчит модныхтой төстэй байна. Титэм зөвтэй, салаалсан мөчрүүд нь гол ишний үзүүрийн дөрөвний гурвыг эзэлсэн байх шаардлагатай. Үндэсний хувьд мөн гурваас доошгүй бүдүүн гол үндэстэй, салаалсан үндэс ихтэй төдийгүй үржил шимтэй хөрс шороотой нь хамт авна.

Шилмүүст модны суулгацын үндсэн салаа мөчрүүдийг доороос нь өөд шуухдаа холтосны гадаргаас 5-10 мм-ээс илүүгүй хэмжээнд огтолж, үлдсэн ёзоорыг тосон будгаар будаж өвчлөхөөс сэргийлэхийн дээр хортон шавьж, нарны хэт халалтаас хамгаалж шохойгоор

будсан байна. Ойгоос стандартын шаардлага хангасан мод авахын тулд ойн зах, чөлөөнд байгаа хэвийн өсөлттэй, зөв хэлбэр хэмжээтэй залуу зулзаган 1.5-5.0 м өндөртэй модыг сонгоно. ТХГН-ийн тухай хуулийн дагуу БЦГ-аас мод бэлтгэхийг хориглодог тул суулгац сонгох газрыг анхаарч үзэх нь зүйтэй.

Тус бүсийн нөхцөлд Улиас, Хар мод, Гацуур, Хус, Хайлаас, Улиангар, Нарс, өрөл зэрэг шилмүүст ба навчит мод, Долоогоно, Монос, Бургас, Тавилгана, Нохойн хошуу, Тэхийн шээг, Шар хуайс, Буйлс, Гүйлс зэрэг олон төрлийн сөөг ургамлыг тарьж болно.

Төрөл бүрийн мод ургамлын ургах нөхцөл нь ялгаатай, нэг хэсэг нь уулын өвөр, бэл, хуурай сайр, нөгөө нь уулын ар, голын хөндий дагуу чийглэг хөрсөнд ургадаг. Нарлаг задгай газрын мод саглагар титэмтэй боловч угаараа бүдүүн муруй хахир иштэй байх нь цөөнгүй. Угаараа бүдүүн модны үндэсний систем хүчирхэг, салаа салбар ихтэй учраас заасан хэмжээний дагуу ухаж авсан ч гол үндэс хэрчигдэж, нарийн үндэс бараг үлддэггүй.

Тарих модыг сонгохдоо үндэсний хүзүүнээс дээш аажмаар нарийссан туяхан иштэй, шовгордуу титэмтэй, гоолиг модыг сонгож авах нь чухал. Ийм мод залуу байдаг төдийгүй, сэргэх нарийн үндэстэй нь ухаж гаргахад хялбар бөгөөд ихэвчлэн ойн зах, зулзаган ой, залуу төгөлд элбэг ургана. 3-4 м өндөр модны уг, хүзүүвчийг эргэн тойронд 40-50 см зайтай дугуйлан ухаж тохиолдсон том, жижиг үндсийг сүх, хүрз юм уу хурц иртэй багажаар саламчилж цуулалгүй огтолж доошоо мөн энэ хэмжээтэй ухна.

Авсан модныхоо үндэс орчны хөрс, шороог хамгаалахын тулд түүнийг даавуу, шуудайгаар ороож, олсоор сайтар баглана. Хайрцаглан авсан шороо бүхий мод тээвэрлэхэд тохиромжтой.

Хөрс шороо бүхий үндсийг зөв авах нь уг мод ургах гол нөхцөл болдог. Үндэсний шороог 1-1.2 м диаметртэй нүхэнд багтахар бодож 40 см-ын өргөнтэй шуудууг 0.6-0.7 м гүн ухаж модоо авах хэрэгтэй.

Төслийн талбайн хөрс ургамлыг элэгдэл эвдрэлээс хамгаалах, ногоон байгууламж байгуулах талаар дор дурдсан зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна. Үүнд:

- Барилга байгууламжийн үйл ажиллагаанаас талхлагдсан ургамал, элэгдсэн хөрсийг нөхөн сэргээх зорилгоор хар шороон хөрсийг зөөвөрлөн авчирч хөрсжүүлэх элэгдсэн хөрсийг байнга сэргээж байх
- Байгуулалтын ажлын явцад эвдрэлд орсон хөрсийг нөхөн сэргээж, барилга объектын талбайгаас бусад сул газрыг бүрэн хэмжээнд зүлэг ургах нөхцөлөөр бүрэн хангах, ургамалжуулах, тариалсан ургамлыг тухай бүр нь арчилж тордох арга хэмжээ авч хэрэгжүүлж байх
- Тарималжуулалтыг тайлангийн зөвлөмжид заасан технологийн горимын дагуу явуулах шаардлагатай ба мэргэжлийн байгууллагаас технологийн нэмэлт заавар, зөвлөгөө авч хэрэгжүүлэх

Аль болох тухайн орчинд ургадаг, дасан зохицох чадвартай мод, бут, сөөг, олон наст ургамлыг хольж тариалах нь зүйтэй.



### 3.2.5 Хог хаягдлын менежмент

- Ахуйн хатуу хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, ариутгах, тээвэрлэх графикийг гаргаж, холбогдох байгууллагатай хог хаягдлыг тогтмол хугацаанд ачиж, зайлуулах гэрээ байгуулан ажиллах шаардлагатай.
- Хатуу хог хаягдлыг шууд хөрсөнд хүрэхгүйгээр зориулалтын битүү тагтай, ялаа шавьж үржихээс сэргийлсэн ариутгал хийсэн саванд хуримтлуулах
- Хүрээлэн буй орчинд гаргаж буй хаягдал бохир ус нь MNS 4943:2014, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага" стандартын шаардлагыг хангасан байх
- Ариун цэврийн өрөө, бохир усны цооног нь гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, ойн сан бүхий газраас 200 м-ээс багагүй зайд байрлуулах.
- Эко байр сууцны үйлчилгээнд энгийн нүхэн жорлонг ашиглахгүй ба байгальд ээлтэй технологи бүхий био жорлонтой байна. Механик цэвэрлэгээ, биологийн цэвэрлэгээ, био реакторын шат дараалсан цэвэрлэгээний бичил байгууламжийг ашиглах
- Төслийн үйл ажиллагааны ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал бохир усыг зайлуулахдаа батлагдсан зураг төслийн дагуу шугам хоолой, цэвэрлэх байгууламжийг байршуулж тодорхой хугацаа бүрд цэвэрлэн зайлуулж шалгаж байх

- Хөрсийг бохирдуулахгүйн тулд шингэн хаягдал бохир усыг бохирын цооногт нийлүүлэхдээ шугам хоолойн хэвийн ажиллах нөхцөлд анхаарах, шугам хоолойн техникийн гэмтэл доголдлыг тогтмол хугацаанд шалгаж байх, засвар, үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар чанартай хийлгэх, уг тайлангийн 1.4 дэд бүлэгт зөвлөсөний дагуу бага оврын бохир ус цэвэрлэх байгууламж суурилуулах, шаардлагатай.
- Ахуйн хог хаягдлыг (баглаа боодлын хайрцаг, сав, цаас, нийлэг болон металл сав, уут, хаягдал г.м) ангилан тусгай саванд нэгтгэн байрлуулж зөөвөрлөн хаяна.
- Хатуу хог хаягдлыг агуулах дээрх сав, хайрцагт ан цав гарсан эсэхийг байнга шалгаж, хэрэв ан цав гарсан тохиолдолд тухай бүр нягт нямбай бөглөж засаж байх
- “Хог хаягдал хадгалах зориулалтын цэг”-ийг байр сууц, хоолны газраас 60 м-с багагүй зайд бие засах газраас тусад нь, зонхилох салхины доод зүгт байрлуулж, салхинд хийсгэхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн, хөрсөнд шингээпт үүсэхээс хамгаалсан байна.
- Хог хаягдлыг зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлэхэд “MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал, Ерөнхий шаардлага” стандартыг баримтлах
- Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх. Үүнд:
  - Дахин ашиглах болон шатааж болох боломжтой хог хаягдал: төрөл бүрийн цаас, картон цаас, шингэний тетропак савалгаа, хуванцэр сав, сав баглаа боодол, хөнгөн цагаан, металл, зэс, гууль, саа, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут
  - Бусад хог хаягдал: үнс, түргэн муудах хоол, хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглагдах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдал
  - Ахуйн аюултай хог хаягдал: өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал (ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй), хортон шавж, мэрэгчдийг устгах хор, мөнгөн ус агуулсан хаягдал (термометр, мөнгөн ус ашигласан унтраалгазалгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, энэ төрлийн гэрэлтүүлгийн хэрэгсэл), электрон барааны хаягдал (компьютер, телевизор, гар утас), аэрозол буюу шүршигч савтай бүтээгдэхүүний хаягдал (пропан ципиндр), түлэгч, идэмхий бодисууд (цэвэрлэгээний бодис), хөргөх бодис агуулсан гэр ахуйн бараа, зарим тусгай батерей (лити, никель кадми), дарь, радио идэвхт хаягдал (утаа мэдрэгч) зэрэг орно.
- Нийтийн эзэмшлийн тапбай, үйпчилгээний орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байрлуулна.
- Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаапах талбайг хог хаягдалгүй, цэвэр цэмцгэр байлгана.
- Нэг удаагийн хэрэглээний зүйлээс татгапзаж, дахин ашиглагдах материалаар хийсэн эд зүйлс хэрэглэнэ.
- Хог хаягдлын талаар зочдод сурталчилгааны материал тарааж, танилцуулга хийнэ
- Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт нийлүүлэх

- 
- Төслийн байршлын онцлогтой холбогдон гадаргуугийн урсац ус зайлуулах байгууламж төлөвлөж, уг байгууламжийг цэвэр орчинтой байлгахад анхаарах хэрэгтэй.
- Төслийн хүрээнд баригдах зарим барилга байгууламжуудыг барьж тохижуулахдаа аль болох тэгш газрыг сонгон авч төслийн талбайн ургамал нь сийрэг буюу талхлагдсан газруудад (барилга байгууламжийн эргэн тойрон, үүд хаалга зэрэг хүний хөлд үргэлжид өртөж байдаг) олон наст ургамлын үр, бут сөөг суулгаж, байнга арчилж, тордож байх (тус тайлангийн зөвлөмжийн хэсэгт тусгасан тарималжуулалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээний дагуу явуулна).

### 3.2.6 Бусад арга хэмжээ

- Төсөл орчмын талбай, автомашины зогсоолыг хатуу хучилттай болгох,
- Авто тээврийн хэрэгслийн зогсоолыг цардаж цементлэхийн өмнө 3-5 см зузаантай наанги /шавар/ шороо дэвсэж нягтруулан индүүдэж авто тээврийн хэрэгслийн бохир тос, бензин үл нэвчүүлэгч /экрэн/ хаалт хийж өгөх
- Авто зогсоолыг талбайн ус зайлуулах шугамтай холбох
- Хуурай хог хаягдлыг таглаатай нийлэг эсвэл металл саванд хуримтлуулан тээвэрлэж байх /цаашид хуурай хог хаягдалгүй байх технологи нэвтрүүлэх/
- Замын тэмдэгтүүд, ялангуяа байгаль орчинг хамгаалах, ТХГН-тай холбоотой /БЦГ/ сурталчилгааны самбар, сануулгыг сүрлэг бөгөөд үзэмжтэй хийж байрлуулах
- Жигүүртэн шувуудын үүр засах, бололцооны хэрээр тэжээл тавьж өгөх зэргээр орчиндоо дасгах
- Тусгай хамгаалалттай бүсэд ан амьтан агнахгүй байх арга хэмжээ авах
- Орчныхоо байгалийн нөхцөлийг сайтар таньж мэдэх
- Хөрс, хөрсний усыг бохирдуулахгүй байх
- Орчны мод, бут сөөг, бусад ургамлыг гэмтээхгүй байх
- Тээврийн хэрэгслийг зөвхөн зориулалтын замаар явуулах
- Эвдрэлд өртсөн хөрс, ургамлыг нөхөн сэргээж, ногоон байгууламж бий болгох
- Ахуйн аливаа хог, бохирыг ил задгай орхихгүй, энэхүү тайланд тусгагдсан заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай.

### 3.3 Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Байгаль орчныг хамгаалах болон орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар ажиллагсад, үйлчилгээний ажилтнуудад жил бүр үйлчилгээ эхлэхээс өмнө тодорхой хугацаагаар байгаль орчны мэргэжилтэн, байцаагчдыг оролцуулсан сургалт семинар зохион байгуулж байх
- Үйлчлүүлэгдийн тоог өөрийн хүчин чадлаас хэтрүүлэхгүй байх
- Байгаль орчныг хамгаалах хууль, орчны байгалийг сүйтгэхгүй байх талаар мэдээлэл сурталчилгаа, анхааруулах хуудас бэлтгэж, сурталчлах

-

- Жуулчны баазын дотоод дүрэм, журмыг боловсруулж ажилчид, үйлчлүүлэгчдэд танилцуулж мөрдүүлэх
- Аливаа гал түймрээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжүүдийг танилцуулж байнга анхааруулж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, болзошгүй гэнэтийн гал түймэр унтраах хэрэгслийг дүрэм журмын дагуу бэлтгэж бэлэн байлгах, гал гарсан тохиолдолд богино хугацаанд унтраах арга барилыг эзэмшүүлж ажилтнууд тодорхой чиглэлээр ажиллах хуваарьтай байх
- Жил бүр үйлчилгээний төлөвлөгөөндөө байгаль хамгаалах зардлыг тусган хэрэгжүүлж байх
- Байгаль хамгаалах талаар авсан арга хэмжээ, байгаль орчны төлөвлөгөөг хэрхэн биелүүлсэн, хяналт шинжилгээний дүнгийн талаар жил бүр тайлан бичиж орон нутгийн захиргаа, байгаль орчны хяналтын албадад тогтоосон хугацаанд хүргүүлж байх
- ТХГН-ын талаарх хууль тогтоомж, дүрэм журам болон өөрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл, сурталчилгаа хийхээр төлөвлөх
- Уламжлалт соёл, ёс заншлаа баримтлах, гадны соёлыг хэт даган дуурайхаас сэргийлэх Амралтын газрын барилга байгууламж нь барилгын норм, дүрэм, нийтэд үйлчлэх шаардлага хангасан байх  
Байгалийн гэнэтийн ослын даатгалд хамруулах.
- Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байх
- Галын аюулаас урьдчилан сэргийлэх, дохиолол хамгаалалтын төхөөрөмж суурилуулах, сувилалд галын хор байрлуулж, заавар зөвлөмжийг байрлуулах.
- Жуулчны баазын төв барилгад утааны мэдрэгч, гал гарсан тохиолдолд ашиглах зориулалттай галын автомат гидрант, аврах шат, хаалга, тэдгээрийн байршлын тойм зураглал, яаралтай мэдээлэл дамжуулах цахилгаан холбоо зэргээр бүрэн тоноглох
- Жуулчны баазын ажилтан тус бүрийг болзошгүй ослын үед ажиллах сургалтад хамруулж дадлагажуулах.
- Төв барилгын агааржуулалтын систем, мөн аюул ослын үед хэрэглэх аврах төлөвлөгөө, нөөц хаалгыг төлөвлөх.
- Жуулчны баазын сүлжээний бүрэн бүтэн байдалд 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулах.
- MNS 6426:2013 “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандартын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөх
- Зочдыг ая тухтай байрлуулах, ажилчдын байрлах, бусад үйлчилгээ явуулах байшин, сууц, гэртэй байх
- Эдэлбэр газар үер, газар хөдлөлт, аянга, галын аюулгүй байдлыг хангасан хамгаалалттай, болзошгүй ослын үед ашиглах заавар, схем зургийг нүдэнд харагдахуйц газар ил байрлуулах
-

- - Анхны тусламж болон яаралтай тусламж үзүүлэх нөхцлөөр хангагдсан байх
  - Эко байр сууцны ойр орчимд байгаль орчинтой зөв зохистой харьцах тухай санамжуудыг байрлуулах ба экологийн боловсролын хэсэг, булантай байх
  - Үйлчилгээний ажилтнууд эрүүл мэндийн үзлэгт улиралд нэг удаа хамрагдсан байна.
  - Үйлчилгээний ажилтнууд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэгтэй байна.
  - Үйлчилгээний ажилтнууд байгаль хамгаалал, экологийн зохих мэдлэгтэй байх ба зочдод ТХГН-ийн тухай болон орчны эрүүл ахуйн санамжийг өгдөг байх
  - Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чиглэлээр сургалтад хамрагдсан, тусламж үзүүлэх чадвартай байна.
  - Энгэрийн тэмдэг бүхий дүрэмт хувцастай байх
  - “Ногоон” гэсэн тодотгол бүхий инновацид суурилсан байгаль орчинд ээлтэй, технологи ашиглан нөгөө талаар үйлдвэрлэлийн зардлаа хэмнэх
  - Байгаль орчин мэдээллээс гадна ус, цахилгаан хэмнэх, хог хаягдлыг багасгах, саарал ус эргүүлэн ашиглах талаар анхааруулга, сурталчилгааны материал тарааж, сурталчилгааны арга хэмжээнд нутгийн иргэд, зочдыг татан оролцуулдаг байна. Сурталчилгааны арга хэмжээг орон нутаг дахь Хамгаалалтын захиргаа, түүний мэдээллийн төвүүдээс мэргэжлийн зөвлөмж авч, арга хэмжээг хамтран зохион байгуулах
  - Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжин, нутгийн иргэдээс эрүүл мэндийн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн худалдан авдаг байх, орон нутгийн иргэдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах.
  - Төсөл хэрэгжихээс өмнө тухай байгууллагын орчны газарт Газрын төлөв байдлын чанарын хянан баталгааг хийлгэж, цаашид 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байх
- Төслийн ойролцоо аянга зайлуулагч байрлуулах

-

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10,1-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх.

#### 3.4 Жуулчны баазын зохион байгуулалт, үйл ажиллагаанд анхаарвал зохих санал

- Жуулчны баазын бүх төрлийн үйлчилгээг байгаль орчинд ээлтэй байдлаар төлөвлөх, үйл ажиллагааг явуулахдаа байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах, хүрээлэн буй орчин, биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах талаар арга хэмжээний төлөвлөгөөтэй байх
- Эдэлбэр газар нь нутгийн малчин айлын өвөлжөө, хаваржаанээс 500 м-ээс гадагш зайд байрлах ёстой.
- Эдэлбэр газар нь байгалийн болон түүх соёлын дурсгалт газраас 3 км-ээс гадагш зайд байрлах ёстой
- Эдэлбэр газрын байршлыг сонгохдоо гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсээс гадагш; хамгаалагдсан ойн сан бүхий газраас 200 метрээс гадагш сонгоно. Сувилалын газар нь усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж ажиллах. /Тус сувилалын газар нь усны эрүүл ахуйн бүсээс гадна 500 м-ийн зайд байрладаг./
- Төв замаас тухайн эдэлбэр газар хүртэл нэг замтай байх ба замын дагуу (500-1000) мийн зайд "MNS 4597:2003, Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" стандартын дагуу цогцолборын хаяг бүхий замын тэмдгийг байрлуулах
- Тээврийн хэрэгслийн /авто/ зогсоолыг байр, сууц, байгууламжаас 200 м-ээс багагүй зайд байрлуулах ба тээврийн хэрэгслийн зогсоол нь "MNS 5342:2007, Автомашины зогсоол, ангилал, ерөнхий шаардлага" стандартын шаардлагыг хангасан байх
- Ердийн хөсөг, морь уналгын зогоолыг авто машины зогсоолоос тусад нь байрлуулах
- Сувилалын газрын байгууллагын үйл ажиллагааг илэрхийлсэн нэр хаяг бүхий самбар, ногоон байгууламж, явган хүний зам, олон нийтийн амралт, тоглоомын талбай, тээврийн зогсоол зэрэг нь тэмдэг тэмдэглэгээтэй байна.
- Эдэлбэр газарт цогцолборын хүчин чадалд нийцсэн зочны байр сууцнаас гадна олон нийтийн болон мэдээллийн хэсэг, хоол болон үйлчилгээний байр, ариун цэврийн болон бие засах газар, албан буюу ажилчдын үйлчилгээний байр, байгууламжтай байх
- Байр сууц, байгууламж нь амралтын үндсэн шинж чанарыг хадгалсан, тухайн орчны байгаль ландшафтын дүр төрхөд нийцсэн, түүхийн соёлын өвийг хүндэтгэсэн хийц загвартай байх ба барилгын газар дээрх давхар хоёр давхраас өндөргүй байх
- Байгууламжийн барилгын гал тэсвэршилтийг "БНБД 31-03-03. Олон нийт иргэний барилга"-ийн дагуу тооцож төлөвлөн, "БНБД 3.05.06.90, Цахилгаан техникийн ажил",

"БНБД 21.01.02, Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал", "БНБД 40\*01-06, Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж", "БНБД 41-01-11, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер" зэрэг барилгын норм ба дүрмүүд, "MNS 4244:1994, Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" зэрэг стандарт. баримт бичгүүдийн шаардлагад нийцсэн байх

- Нэг зочинд ногдох талбайг эко цогцолбор нь улирлын ажиллагаатай бол 4.5 м<sup>2</sup>, байнгын ажиллагаатай бол 6 м<sup>2</sup> байхаар [БНБД 31-03-03-ын 2.11. (В), 4-р хүснэгт.], хооллох танхимын нэг суудалд ноогдох талбай 1,2 м<sup>2</sup> [БНБД 31 -03-03-ын 2.22. (А-Е)] байхаар төлөвлөх.

Байр сууцны хана, дээвэр шаланд дулааны алдагдал багатай материал ашиглах ба барилгын хаалга, цонхны холбогдох стандартуудын шаардлагыг хангасан байх

Ариун цэврийн газар нь агааржуулагч сэнстэй байх

- Амрагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс гар чийдэнгийн нөөцтэй байх - Амрагчдын цахилгаан, дулаан хэмнэх талаар танилцуулга хийдэг байх.
- Байгальд хор нөлөөгүй, байгальд уусдаг угаалгын нунтаг болон саван, шампунь хэрэглэх ба энэ тухай анхааруулгыг аялагчдад мэдэгдэх Эрчим хүч
- Эрчим хүчний хэрэглээний 30-аас багагүй хувийг сэргээгдэх буюу нар, салхины эрчим хүчээр хангах
- Гадна талбайн гэрэлтүүлэгт хөдөлгөөний мэдрэгчтэй, нарны зайгаар ажилладаг гэрэл ашиглах
- Эрчим хүчний хэмнэлттэй гэсэн тодотгол бүхий цахилгаан хэрэгсэл (хөлдөөгч халаагуур, угаалгын машин, утасны зай цэнэглэгч г.м.) ашиглана.
- Орчин үеийн халаагч тоног төхөөрөмжийг нарны энергийн хуримтлуулагчтай хослуулах
- Эрчим хүч хэмнэх тоног төхөөрөмж – сүүн гэрэл хэрэглэх
- Нарны болон салхины эрчим хүчийг ашиглах
- Цахилгаан үүсгүүрийн түлш, шатахууныг аюулгүй ажиллагааны заавар дүрмийн дагуу тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааг зохион байгуулах

Хог хаягдал – Хог хаягдлыг ангилах үйл ажиллагааг хангалтгүй хийснээс тухайн байгууллагад их хэмжээний зардал үүсгэдэг. Хог хаягдлаас зайлсхийх нь илүү үр дүнтэй (Тус тайлангийн хог хаягдлыг багасгах зөвлөмжийн хэсэгт дэлгэрэнгүй оруулав).

- Нэг удаагийн сав, боодлоос татгалзах
- Дахин ашиглах зориулалттай сав боодлыг эргүүлэн авах
- Биологийн гаралтай хог хаягдлыг эргүүлэн ашиглах
- Хог хаягдал хүлээн авах цэг ажиллуулах, байршуулах
- Мэдээлэл түгээх

Ус – Бие засах газарт нийт усны хэрэглээний 1/3 нь зарцуулагддаг. Ус хэмнэх боломжуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх

- Бие засах газарт ус бага хэрэглэх үүднээс ус хаах товчлуурыг
- байрлуулах
- Усны хоолойг байнга шалгаж, ус гоожиж буйг тогтоох

- Усны тоолуур тавих
- Шүршүүр болон гоожуурт хязгаарлагч байрлуулах
- Бохир ус цэвэрлэх бага оврын байгууламж суурилуулах

Талбайн зохион байгуулалт – Тус жуулчны баазын газар нь байгалийн бүрэлдэхүүн хэсэг байх учиртай ба байгаль орчинд эвсэг хэлбэрээр байршуулбал үйлчлүүлэгчдэд таатай сэтгэгдэл төрүүлнэ.

- Ургамал, амьтныг хамгаалах
- Өвс хадагч машин хэрэглэхгүй байх
- Байгаль орчны талаарх танин мэдэхүйн ном түгээх

Байгаль орчинтой уялдсан байдал – Амралтаараа хүмүүс шинэлэг зүйл хүлээн авах дуртай байдаг. Иймээс байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хөгжөөнт хэлбэрээр амралтын хөтөлбөрт оруулах хэрэгтэй.

- Байгаль орчны талаар мэргэшсэн тайлбарлагч ажиллуулах
- Байгаль орчны талаар мэргэжлийн хүмүүстэй уулзалт зохиох
- Шувууны үүр байрлуулах
- Экологийн сэдэвтэй ном, сэтгүүл тараах
- Байгаль орчныг хамгаалах өдрийг зохион байгуулах
- Галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон стандарт, бусад техникийн нормативыг албан тушаалтан, иргэд үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах үүрэгтэй.
- Барилга байгууламжийн хийц, бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд хүн амын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймрийг бага хохиролтойгоор унтраах бололцоог хангасан байна.













### **Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)**

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) Налайх дүүргийн нутаг дэвсгэр нь БЦГ-ийн Баргын өвөлжөөнд “НОМ ЭЭЛ” ХХК-ний TERELJ HILLS LODGE жуулчны бааз байгуулах төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу “НОМ ЭЭЛ” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын яам /-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “НОМ ЭЭЛ” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

**Хүснэгт. 8 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
<b>1. Усны хяналт шинжилгээ</b>					
.1	Усны ерөнхий шинжилгээ	Унд ахуйн уснаас <b>Гүний худаг:</b> 107° 25' 47.01" 47° 52' 17.82"	Жилд 2 удаа	Жилд 2 удаа <b>НИЙТ 144.0</b>	- MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж - MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
<b>2. Хөрсний бохирдол</b>					
3.1	Хөрсний хими физик шинж чанар, хүнд металлын шинжилгээг хийлгэх	Төслийн талбайд 1 цэгээс <b>Цэг:</b> 107°25'56.611"E 47°53'30.492"N	- Жилд 1 удаа, 2 цэгт	2 дээж Жилд 1 удаа /Хөрсний химийн шинжилгээ - 40.0 <b>НИЙТ 58.0</b>	- MNS 3310:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS ISO 10390:2001 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга - MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Тоосжилт дуу чимээний шинжилгээ		-	75000,0	- MNS 17.2.5.12:88 - MNS 17.2.5.11:88 - DUSTRAK8530

Налайх дүүрэг 6-р хороо баргын өвөлжөөнд байрлалтай Тэрэлж Хиллс Лодж жуулчны бааз нь 2016 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны явцад байгууламжын гадаах орчинд 5850ш мод бут тариж ургуулж байгаа болно.

Үүнд

№	Модны нэр төрөл	Тоо ширхэг	Газрын байршил	Арчилгаа
1	Нарс	85	Байгууламжын зүүн хэсэгт	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг
2	Шинэс	100	Байгууламжын зүүн хэсэгт	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэгЮп?
3	Хайлаас	3000	Байгууламжын урд хойд төв хэсэг	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг
4	Голт бор	1200	Байгууламжын урд явган зам дагуу	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг
5	Шар хайлаас	800	Төв барилгын урд баруун террас хүрээлэнд	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг
6	Монос	55	Газрын баруун урд хэсэгт	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг



7	Үхрийн нүд	80	Газрын баруун, зүүн гэрийн гол хэсэгт	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг
8	Чацаргана	80	Газрын зүүн өмнөд хэсэгт	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг
9	Чавга	45	Төв барилгын террас урд хэсэгт	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг
10	Алим	55	Гэрүүдийн зүүн хэсэгт гол байгууламжаар	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг
11	Бөөрөлзгөнө	35	Төв барилгын террасны ард хэсэгт	Байгууламжын нэгдсэн усалгааны системээр гүний худаг ашигладаг ба жилд нэг удаа бордоо хийж хөрсний сийрэгжүүлэлт хийдэг

**2023 онд баазын нийт ногоон төслийн хүрээнд хийгдэх ажил**

1. 2023 онд баазын нийт ногоон төслийн хүрээнд бохир ус тээвэрлэх талбайд хөрсний зүлэгжүүлэлт хийх ба 27 тн-ын танк шугамын системийг Атмор ххк-р хийлгэсэн ба Маргад-Эрдэнэ Уул ххк-р сардаа 3 удаа соруулж тээвэрлүүлдэг.
2. Одоогоор тарисан модны ургалтын арчилгаа голидорлыг жигдрүүлэх хортон шавьжны хор хамгаалах бодисыг цацах
3. Зүлэг тарихад хамрах талбай нь 1 га хүрэхүйц талбайд нөхөн сэргээлт хийх шаардагтай гэсэн хэсэгт нэмэлтээр шириг нөхөх зэрэг болно.

**Ногоон зүлэгжүүлэлтийн мод тарих төсөв**

№	Хийгдэх ажил	Тоо ширхэг	Нэгж	Нийт дүн	Тайлбар
1	Таримал зүлэг хуурай тарих	700м2	1145	801500	
2	Ногоон шириг бетон талбайн хажууд нөхөх	1200м2	1500000	1500000	
3	Шавьжны бодис	1600м2	475000	475000	
4	Хайлаас мод үрсэлгээ	150	4500	675000	
5	Шинэс мод	50	12000	600000	
6	Хөрс шороо элс	1	475000	475000	
	<b>Нийт</b>			<b>4,526,5000</b>	